

7

МЕНЕЖМЕНТИЙН ГАДААД ОРЧИН

Н.Лизунов

Бизнесийн орчинд тасралтгүй өөрчлөлт гарж байна. Бизнесийн орчин ямар байхаас тухайн улсын өрсөлдөх чадвар ихээхэн хамаардаг. Нийгэмд хамгийн чухал гэгдэх ажил хэрэгч, боловсролын хийгээд улсын байгууллагын удирдагчид, дэлхий ертөнцөд болсон саяхны үйл явдлуудын нөлөөгөөр түргэн зуур өөрчлөгдөж буй гадаад орчин, түүний нөлөө, байгууллагын дотоод бүтцэд хэрхэн тусч болох вэ гэдэгт анхаарлаа төвлөрүүлэх нь зайлшгүй чухал.

XX зуунд дэлхийн эдийн засаг дайн дажинтай, эдийн засгийн хөгжлийг түргэсгэх шинжлэх ухаан, техникийн дэвшилтэй, аж үйлдвэржилтийн зуун байлаа.

Манай улсад хувьд бизнес эрхлэхэд АНУ-ын Олон Улсын хөгжлийн агентлагаас 2005 онд явуулсан судалгааны дүнгээс үзэхэд Засгийн газрын хүнд суртал, хөгжөөгүй дэд бүтэц, татварын хувь хэмжээ, хээл хахууль, татварын хууль тогтоомж нь хамгийн их хүндрэл учруулж байгаа 5 хүчин зүйл гэж тэмдэглэжээ.

Монголын эдийн засаг бизнесийн орчны талаар Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Тэнхим /МҮХАҮТ/-ээс цуврал судалгаанууд явуулж байгаа нь дэвшилтэй хэрэг юм. Энэхүү судалгаанд тус байгууллагын гишүүн болон гишүүн бус 159 ААН, байгууллага, жижиг дунд үйлдвэрүүд хувиараа жижиг бизнес эрхлэгчид оролцсоноос 28,3% нь худалдааны, 22,6% нь үйлдвэрлэл эрхэлдэг, 18,9% нь үйлчилгээний, 9,4% нь бусад үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага байсан байна.

Манай улс сүүлийн 2-3 жилд бизнесийн орчныг сайжруулах талаар нэлээд эрчимтэй арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Тухайлбал засгийн газар-Хувийн хэвшлийн хамтарсан Зөвлөлдөх хорооны ажил тогтмолжиж үр бүтээл нь дээшилж байна. 2004 оны 4 сард Монголын бизнес эрхлэгчдийн анхдугаар

чуулганыг хийж төр засаг, бизнес эрхлэгчид санал бодлоо солилцсон нь ихээхэн үр дүнтэй арга хэмжээ боллоо. Энэхүү чуулганы мөрөөр Засгийн газрын 143-р тогтоол гарган бизнесийн орчныг сайжруулах талаар төр засгаас авах арга хэмжээний хөтөлбөр гарган хэрэгжүүлж байгаа юм.

Мөн үйлдвэр худалдааны яам, АНУ-н Хөгжлийн агентлагийн шинжээчдийн дүгнэлтийг үндэслэн “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулан 2005 оны 4-р сард баталжээ.

2006 оны 9 сард дотоодын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг анх удаа зохион байгуулжээ. Жижиг дунд бизнесийг дэмжих зорилготой 2 үе шаттай зээлийг Японы засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлэхээр тохиролцож энэ төслийн хүрээнд 26 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудаар дамжуулан олгож эхлээд байна. Үйлдвэр Худалдааны Яамны жижиг дунд бизнесийг дэмжих сангаас ч хөнгөлөлттэй зээлийг олгож байна.


Мөн Олон Улсын Валютын сангаас үйлдвэрлэл хөгжихөд нь үнэлгээ өгөхөд үнэлгээнд манай улс +В үнэлгээ авсан. Тиймээс ОУВС-с манай оронд үйлдвэрлэл хөгжихөд таатай орчин бүрдсэн гэж үнэлсэн байна.

НҮБ-н “Монголд үйлдвэрлэл хөгжүүлбэр” төслийн хүрээнд хэрэгжиж буй “Нэг суурин нэг бүтээгдэхүүн” хөтөлбөртэй нийцүүлэн орон нутагт тухайн аймаг сумын брэнд бараа үйлчилгээг бий болгох, мэргэжлийн сургалт, зөвлөгөө өгч сонгон шалгаруулалт хийн 140 гаруй саналаас шалгарсан ААН-дэд дэмжлэг үзүүлэх ажил хийгдэж байна.

Түүнчлэн дэлхийн худалдааны байгууллагын гишүүнчлэлийн болон одоогийн мөрдөж байгаа гэрээ хэлэлцээрүүдийн давуу талыг бүрэн ашиглах, өндөр хөгжилтэй орнуудын зах зээлд экспортлох бараа, бүтээгдэхүүний хэмжээг хязгаарлахгүйгээр татваргүй нийлүүлэх боломжийг ашиглах талаар төрийн ба бизнесийн байгууллагууд идэвхтэй хамтран ажиллаж байна. Монгол Улсын Их Хурлаас шинэчлэн найруулсан “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай”, “Онцгой албан татварын тухай” хуулиудыг 2007-01-01-ээс эхлэн даган мөрдөж байна.

Дүгнэж үзвэл бизнесийн орчныг зохистой бүрдүүлэх төрийн, төрийн бус, бизнесийн байгууллагын хамтын ажиллагаа жил ирэх тусам зүгширч байгаа нь Монголын бизнес, зах зээлийн хөгжилд шинэ боломжийг нээж байгаа юм. Өнөө үед гадаад орчны энэхүү өөрчлөлт хувирлыг авч үзэлгүйгээр цааш хөгжих тухай ярих боломжгүй болжээ.


Гадаад орчны хүчин зүйлүүд байгууллагад нөлөөлөхүй



Жеральд Белл: “Байгууллагын гадаад орчинд хэрэглэгч, өрсөлдөгч, засгийн газрын байгууллага, бэлтгэн нийлүүлэгч, санхүүгийн байгууллага, хөдөлмөрийн нөөцийн эх үүсвэр зэрэг байгууллагын үйл ажиллагаанд холбогдох бүх зүйл багтах учиртай” гэж цохон хэлжээ.

Байгууллагын хүрээллийн орчинг дотор нь шууд болон дам нөлөөллийн гэж заагладаг. Байгууллагын үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг мөн байгууллагын үйл ажиллагааг өөртөө шууд тусгадаг хүчин зүйлүүдэд: бэлтгэн нийлүүлэгч болон өрсөлдөгчид зэрэг хамаардаг бол дам нөлөөллийн хүчин зүйлүүдэд: эдийн засгийн байдал, шинжлэх ухаан техникийн дэвшил, нийгэм соёлын болон улс төрийн өөрчлөлт, нийгмийн бүлгийн сонирхол, тухайн байгууллагын хувьд нөлөөлж болохуйц гадаад орнуудад болж буй үйл явдлууд хамаарна.

Шууд нөлөөллийн орчин



Шууд нөлөөллийн орчин:

Бэлтгэн нийлүүлэгч: Байгууллагын үндсэн орц болох материал, тоног төхөөрөмж, эрчим хүч, капитал, ажиллах хүч зэргийг бэлтгэн хангагчийг бэлтгэн нийлүүлэгч гэдэг. Эрчим хүчний нийлүүлэлтээс шалтгаалахгүй байгууллага хэрэг дээрээ байхгүй. Шатахууны үнэ удаа дараа эрс өсч байгаа нь байгууллага бүрт ямар нэгэн хэмжээгээр нөлөөлсөн. Үнийн энэ өсөлтөд чухамдаа гадаад орчин эрчимтэй нөлөөлсөн билээ. **Материал, түүхий эд:**

Зарим байгууллагын хувьд материал, түүхий эд тасралтгүй урсгалаар бэлтгэгдэж байх ёстой байдаг. Тухайлбал машины үйлдвэр, таваар хуваарилагддаг пүүс болон жижиглэнгийн дэлгүүрүүд ийм байдаг. Материал, түүхий эдийн талаар янз бүрийн үзэл бодлоор тогтсон системтэй байна.

Манай улсын хувьд ХАА-н бүтээгдэхүүнээр баялаг. Малын тооны өсөлтийг авч үзвэл.

Малын тооны өсөлтийн байдал /мянган толгой/

Он	Аүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1990	25856,9	537,5	2262	2848,7	15083	5125,7
1995	28572,3	367,5	2648,4	3317,1	13718,6	8520,7
1999	33568,9	355,6	3163,5	3824,7	15191,3	11033,9
2000	30227,5	322,9	2660,7	3097,6	13876,4	10269,8
2001	26075,3	285,2	2191,8	2069,6	11937,3	9591,3
2002	23897,6	253	1988,9	1884,3	10636,6	9134,8
2003	25427,7	256,7	1968,9	1792,6	10756,4	10652,9
2004	28027,9	256,6	2005,3	1841,6	11686,4	12238
2005	29901,8	250	2001,2	1940,3	12582,9	13127,4
2006	34802,4	253,5	2114,8	2167,9	14815,1	15451,7

Капитал: Пүүс капиталгүйгээр үйл ажиллагаа явуулж чадахгүй. Хөрөнгө оруулах эх үүсвэр хэд хэдэн төрөлтэй, тухайлбал, банкны зээл, улсын сангийн болон төслийн эх үүсвэртэй байж болно.

Хөдөлмөрийн нөөц: Авьяаслаг менежерүүдийг шилж авч дэмжин ажиллуулах нь орчин үеийн байгууллагын гол анхаарах зүйлийн нэг болсон байна. Учир нь технологи, материал, капиталыг үр ашигтай ашиглаж байгууллагын зорилгыг хэрэгжүүлэх шийдвэрлэгч хүчин зүйл бол хүн. Зарим орны хувьд гадны хямд ажиллах хүч авахыг ч хичээдэг. Ажиллах хүчний талаар үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай байгуулдаг хөдөлмөрийн гэрээ бол уг чанартаа ажиллах хүч нийлүүлэгчтэй байгуулсан гэрээ юм.

Монгол улсын хүн хүчний нөөц, түүний ашиглалтын судалгаа

№		Оны эцсийн дүн /мян.хүн/			Өсөлт, бууралт
		1995	2000	2005	
1.	Хүн ам	2317,5	2407,5	2562,8	110,6
2.	Хөдөлмөрийн насны хүн ам	1186,7	1374,4	1577,0	132,9
3.	Хөдөлмөрийн нас хэтэрсэн хүн ам	156,0	188,0	182,2	116,8
4.	Хөдөлмөрийн нөөц	1087,4	1283,9	1498,7	137,8
5.	Хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүн ам	1050,5	1269,5	1491,2	142,0
6.	Ажиллагчид	794,7	809,0	968,3	121,8
7.	Үйлдвэрлэлийн салбарт ажиллагсад	593,2	507,9	549,0	-7,5
8.	Үйлчилгээний салбарт ажиллагсад	201,5	301,1	419,3	208,1
9.	Хөдөлмөрийн насны суралцагчид	102,0	153,7	237,0	232,4
10.	Ажиллаж байгаа хүүхэд	6,7	1,8	0,4	-94,2
11.	Ажиллаж байгаа өндөр настан	30,2	12,6	7,1	76,5
12.	Хөдөлмөр эрхлээгүй хүн ам	217,7	282,7	260,4	119,6
13.	Ажилгүйчүүд	45,1	38,6	32,9	-27,1
14.	Ажиллах хүчин	839,8	847,6	1001,2	119,2
15.	Ажилгүйдлийн түвшин	5,4	4,6	3,5	-1,9
16.	Хөдөлмөрийн нөөцийн ашиглалт	73,1	63,0	64,6	-8,5
17.	Хүн амд үйлдвэрлэлийн слабарын эзлэх хувь	25,6	21,1	21,4	-4,2
18.	Хөдөлмөрийн хүчний ашиглалт	94,6	95,4	96,5	1,9
19.	Хөдөлмөр эрхлээгүй хүн амыг ажиллагчидтай харьцуулсан хувь	27,4	34,9	26,9	-0,5

Хууль: Байгууллага бүр эрх зүйн тодорхой статустай байдаг. Энэ нь хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулж, татвар төлж, хариуцлага хүлээнэ гэсэн үг. Улс төрийн бодлого шийдвэрийг илэрхийлэгч нь хууль эрхзүйн иж бүрдэл байдаг.

Монгол улсын засгийн газраас үндэсний үйлдвэрлэлийн хөтөлбөрийг боловсруулаад 10-аад жилд хэрэгжүүлж ирсэн бөгөөд улс төрийн ямар ч хүчин төр барьж байсан тус хөтөлбөрийн хэрэгжилтэнд онцгой анхаарал тавин ажиллаж ирсэн. Татварын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт нь бүтээгдэхүүний үйл ажиллагаанд шууд нөлөөлнө. Нөгөө талаар татварын бааз суурийг өргөтгөх сайн талтай болсон билээ.

Монгол улсын хэмжээнд нийт 19 төрлийн татвар, 5 төрлийн хураамж, 6 төрлийн төлбөрийг авч байна. Бизнесийн үйл ажиллагааг зохицуулдаг дараах төрлийн хуулиуд байна. Үүнд, Татварын ерөнхий хууль, НӨАТ – ын тухай хууль, Худалдааны татварын хууль, Тээврийн хэрэгслийн татварын хууль, ХАОАТ – ын тухай хууль, ААНБОАТ – ын тухай хууль, Гаалийн албан татварын хууль, Үл хөдлөх хөрөнгийн албан татварын хууль гэх мэт.

Татвартай холбоотой ямар асуудлууд бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулдагийг тодорхойлоход МҮХАҮТ-н судалгаанд хамрагдсан 159 ААНБайгууллагын 87,8% нь татварын хураамж өндөр, 83,9% нь татварын хяналт шалгалт их, 75% нь татварын байцаагчдын харьцаа муу гэж хариулсан байна.

2000-2006 онд татварын орлогын бүтэц /хувиар/

	2000	2001	2002	2003	2004	2005	2006
Татварын нийт орлого Үүнээс:	100	100	100	100	100	100	100
Орлогын албан татвар	24,1	19,7	20,2	20,2	24,7	25,7	37,9
Нийгмийн даатгалын шимтгэл	15,1	16,4	15,1	15,7	14,1	13,8	10,6
НӨАТ	29,2	31,7	33	30,1	28	26,1	22,8
Онцгой албан татвар	15,7	16,2	14,3	14,6	12,1	11,4	9,5
Тусгай үйлчилгээний албан татвар	2,7	2,7	2,4	2,4	1,9	1,1	1,3
Гаалийн албан татвар	8,6	8,2	6,8	8,1	7,7	8,2	6,9
Бусад татвар	4,5	4,4	7,2	7,8	10,6	12,1	10,2

Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжууд маш богино хугацаанд өөрчлөгддөг, мөрдөгдөж байгаа татварын хуулиудаар тогтоосон татвар , төлбөр, хураамжуудын ачаалал нь гадаадын орнуудтай харьцуулахад өндөр байдаг гэж бизнес эрхлэгчид дүгнэсэн байна.

Татварын шинэ хуулийн дагуу 2007 оны I сарын 1-ээс бизнес эрхлэгчдэд илүү таатай орчин бүрдүүлсэн татварын шинэ тогтолцоо үйлчилж эхэлсэн нь дээрх дутагдлыг даван туулах эрхзүйн чухал нөхцөл боллоо.


Төрийн байгууллага: Төрийн байгууллагууд тухайн чиглэлээрээ ажиллан хуулийн биелэлтийг хариуцдаг. Тухайлбал бизнесийн болон бусад байгууллагууд татварын хуулийг өөрийн үйл ажиллагаанд чанд мөрдөх учиртай.

Гэтэл төрийн яамд харьяа байгууллагуудтай харьцахад бизнес эрхлэгчдэд зарим тохиолдолд хүндрэлтэй байдаг нь тийм ч гайхмаар зүйл биш болсон бөгөөд үүнийг судалгаанд оролцогчдын дүн батлан харуулж байна. ААН-үүд өөрсдийн байнга харьцдаг төр засгийн байгууллагуудаас хамгийн их хүнд сурталтай, зардал чирэгдэл учруулдаг байгууллагыг татварын алба, гаалийн байгууллага, яамд, агентлаг, хот дүүргийн захиргаа зэрэг төр, захиргааны байгууллагуудыг нэрлэсэн байна.

Хэрэглэгчид: Хэрэглэгчгүй байгууллага гэж ер байдаггүй. Бизнесийн байгууллагын оршин тогтнох нь хэрэглэгчээ олж чадсан эсэх, тэдний эрэлтийг хангаж чадах эсэхээр тодорхойлогдоно. Парламентийн сонгуулийн өмнөх компани бол сонгогчдыг /хэрэглэгчдийг/ олж авч буй хэрэг юм.

Соёл иргэншлийн хэв маягаар харьцангуй ялгаатай зан төлөвийн загварыг бий болгосон. Суурин соёл иргэншлийг төлөөлж буй хот суурин газрын хүн амын зан төлөвөөр ерөнхий шинжээрээ бусад орнуудынхтай ойролцоо боловч Монголын өвөрмөц соёл зан заншлыг шингээсэн онцлог шинж бас байдаг. Нүүдлийн соёл иргэншлийг төлөөлж буй худалдан авагчийн сэтгэлгээнд ч гэсэн /хөдөөгийн/ суурин амьдралтай хэрэглэгчдийн зан төлөв рүү ойртох чиглэлээр өөрчлөлт гарч байна.


Манай улсын хэрэглэгчийн зах зээлийн бүтэц дараах хэлбэртэй байна




Өрсөлдөгчид : Өрсөлдөөн бол байгууллагын гадны хүчин зүйл мөн. Хэрэглэгчдийн хэрэгцээг бусдаас илүү хангаж үнэлэгдэхэд өрсөлдөөний агуулга оршино. Тэгэхдээ өрсөлдөөний объект нь ганцхан хэрэглэгчид биш. Өнөөгийн нөхцөлд өрсөлдөөнийг баримжаалах аргагүй болж. Гэнэт хүчтэй өрсөлдөгч гарч ирэх тохиолдол их болсон байна.

“Сүү” ХК сүүн бүтээгдэхүүний зах зээл дээр 50 жил үйл ажиллагаа явуулж байна. Гэтэл сүүлийн хэдхэн жилийн дотор “Мон milk” компани сав баглаа боодол сайтайгаар, хүчтэй реклам сурталчилгаа явуулан гарч ирсэн бол “Монсүү” ХХК хүүхдийн тэжээлийн үйлдвэрлэлээр тэргүүлж тухайн зах зээл дээр өрсөлдөгч болон гарч ирлээ.

Дам нөлөөллийн орчин



Инфляци болон мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлт, оны эхнээс хувь



Зураг. Инфляци, мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлт, оны эхнээс хувь

Бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд банк, зээл, санхүүгийн бодлого, мөнгөний төлбөрийн чадвар, инфляцийн түвшин зэрэг эдийн засгийн үзүүлэлтүүд ихээхэн нөлөөлдөг. Манай улсын эдийн засагт гарч буй нэг томоохон өөрчлөлт бол банк санхүүгийн салбарын хөгжил юм. Өнөөгийн байдлаар 16 арилжааны банк, 140 гаруй банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байна. Зах зээлийн жам ёсоор бол санхүүгийн салбарт үйл ажиллагаагаа явуулах байгууллагын тоо нэмэгдсэн нь зээлийн хүүг бууруулж, зээл авах боломжийг нэмэгдүүлнэ.


Хүн амын амьжиргааны түвшин буюу гар дээр нь очиж буй мөнгөн орлого нэмэгдснээр хүмүүсийн худалдан авах чадвар өсөх болно. Төрөөс олгож буй олон төрлийн тэтгэвэр тэтгэмжүүд, мөн төрийн албан хаагчдийн цалингийн өсөлт, амьжиргааны доод түвшинг нэмж тогтоосон зэрэг нь хүмүүсийн худалдан авах чадварыг нэмэгдүүлэхэд нэг талаар чухал нөлөө үзүүлж байгаа юм.

Монгол улсын макро эдийн засгийн зарим үзүүлэлтийн хандлага

Үзүүлэлт	1998	2000	2004	2005	2006	2007*
ДНБ-ний жилийн цэвэр өсөлт /%/	3,5	1,06	10,7	6,2	7,5	8,6
Нэг хүнд ноогдох ДНБ /мян.төг/	351,1	426,2	758,7	889,6	1121,2	1265,2
Нийт мөнгө M2 /тэрбум төгрөг/	167,2	258,8	847,0	1170,1	1518,8	1956,2
Инфляцийн жилийн түвшин /%/	6,0	8,1	11,0	9,5	6,3	5,0
Төсвийн нийт орлого /тэрбум төгрөг/	225,5	351,0	713,1	837,9	1209,2	1295,6
Төсвийн нийт зарлага /тэрбум төгрөг/	342,2	429,6	752,5	764,6	1046,5	1428,0
Ажилгүйдлийн түвшин	5,9	4,6	3,6	3,3	3,3	3,3

Инфляци. Сүүлийн 4 жилд хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифийн өсөлт харьцангуй бага байлаа. Инфляцийн түвшин 2003 оноос харьцангуй буурч 2002 онд шилжилтийн үеийн хамгийн бага түвшиндээ хүрсэн юм. Өмнөх онуудад иргэдийн хадгаламж үлэмж өсч байснаас мөнгөний нийүүлэлт өссөн ба банкнаас гадуурх мөнгөний хэмжээ төдийлөн өсөөгүй байна. Монгол банкнаас нөөц мөнгөний төлөвлөлтийн бодлого баримталж банкнаас гадуурх мөнгөний өсөлтийг сүүлийн дөрвөн жил 10.0 хувиас доогуур байлгаж чадсан нь инфляцийн түвшинг бууруулсан байна. Банкнаас гадуурх мөнгөний өсөлт 2000-2004 оны дунджаар 9.1 хувьтай байна.

Ажилгүйдэл /1990-2005он, хувиар/




Зээлийн хүү. 2004 оны эцсийн байдлаар арилжааны банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү төгрөгийн зээлд 30.0 хувь, валютын зээлд 17.9 хувь байна. 2004 онд хувийн салбарт олгосон зээлийн хэмжээ 2003 оны эцсийнхээс 53.8 хувь буюу 180.7 тэрбум төгрөгөөр өсч 516.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь эдийн засгийн үйл ажиллагаа сэргэн идэвхжиж зээлийн эрэлт харьцангуй өндөр байгааг харуулж байна. Эдийн засгийн өсөлтийн хурдац нэмэгдэж, эдийн засаг дахь зээлийн эрэлт ийнхүү өндөр байгаагаас зээлийн хүү дорвитой буурахгүй байна.


Банк санхүүгийн үйлчилгээнүүдээс бизнес эрхлэгчдэд хүндрэлтэй асуудал нь зээлийн хүү, хугацааны асуудал бөгөөд судалгаанд оролцогчдын 92,9 % нь зээлийн хүү өндөр байгааг, 88,9% нь хугацаа хэт богино байгааг хүндрэлтэй байна гэжээ. Мөн 36,4% нь банк санхүүгийн зах зээлийн талаарх мэдээлэл хомс гэж хариулсан байна. Мөн барьцаандаа хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн барьцааг чухалчилдагаас жижиг дунд ААН-үүдийн хувьд зээл авахад хүндрэл гардаг байна.

Эдийн засгийн өсөлт.

Эдийн засгийн өсөлт 2004 оны эцэст 10.6 хувьтай гарсан. Эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд хурдасч байгаа ч хөдөө аж ахуй, уул, уурхайн олборлох аж үйлдвэрлэлийн салбарын буюу анхдагч салбарын үйлдвэрлэлээр эдийн засгийн өсөлтийн дийлэнх хэсэг хангагдах болсон нь цаашдын тогтвортой өсөлтийн суурь болж чадахгүй ажлын байрыг дорвитой нэмэгдүүлэхгүй байна. Тиймээс илүү өгөөжтэй боловсруулах аж үйлдвэрлэлийн салбарын өсөлтийг нэмэгдүүлэх шаардлага байгаа юм. Өнөөдөр ДНБ-ний 70%-ийг бүрдүүлж буй салбар бол хувийн хэвшил бөгөөд нийт ажил эрхлэгчдийн ихэнх хувь нь энэ салбарт ажиллаж байгаа гэдэг утгаараа уг салбарын цаашдын ирээдүйн талаар таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх үүднээс засгийн газрын бодлого үүнд чиглэх нь зүйтэй юм.



Эдийн засгийн өсөлт үндсэн салбаруудаар /хувь/



Үйлдвэрлэлийн салбарын өсөлт нь манай улсын эдийн засагт сайнаар нөлөөлж байгаа учраас төр засгийн газраас үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө болон тус дэмжлэг үзүүлж байгаа зэрэг нь үйлдвэрлэл хөгжихөд боломж олгож байгаа юм.

Монгол улсын нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 1000 долларт хүрч байгаа нь эдийн засаг өсч байгааг харуулна. Гэвч бодит амьдрал дээр ард түмний амьдрал төдийлөн дэвжихгүй л байна. Энэ нь дотоодын боловсруулах үйлдвэрлэлийн хөгжил сул, өргөн хэрэглээний ихэнх барааг импортоор оруулж ирдэгтэй холбоотой. Ийм учраас манай улсын хүнсний аюулгүй байдалд маш муугаар нөлөөлж байна.

Экспорт тивээр, сая. ам доллараар

Бүс	2001	2002	2003	2004	2005
Ази	278,5	252,8	344,0	484,4	603,9
Европ	86,3	85,5	91,8	213,6	171,1
Америк	146,7	167,9	143,9	171,4	275,5
Африк	0,1	0,0	1,7	0,1	0,1
Австрали	10,0	17,7	34,5	0,1	14,3
Аүгд	521,5	524,0	615,9	869,7	1064,9

Импорт тивээр, сая. ам доллараар

Бүс	2001	2002	2003	2004	2005
Ази	295,4	330,8	358,5	460,5	526,5
Европ	324,8	320,8	392,3	486,2	577,1
Америк	16,1	26,9	28,4	57,1	64,7
Африк	0,0	0,1	1,2	0,0	0,3
Австрали	1,4	12,2	20,6	17,4	15,7
Аүгд	637,7	690,8	801,0	1021,1	1184,3

Экспортын бүтэц, барааны бүлгээр, хувиар

	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005
Эрдэс бүтээгдэхүүн	44,2	33,8	32,3	35,2	33,6	33,1	34,6	40,7	42,7
Түүхий болон боловсруулсан арьс шир, ангийн үс, эдгээрээр хийсэн бүтээгдэхүүн	4,7	6,0	6,6	7,9	11,3	8,8	8,6	2,7	2,9
Нэхмэл бүтээгдэхүүн	17,0	16,8	28,0	35,9	32,9	27,7	26,9	22,7	18,0
Үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйл	20,6	26,8	21,8	14,1	14,5	22,8	23,3	28,0	31,1
Бүгд	86,5	83,4	88,8	93,1	92,3	92,4	93,4	94,0	94,7

Импортын бүтэц, барааны бүлгээр, хувиар

	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005
Ургамлын гаралтай бүтээгдэхүүн	6,8	5,3	3,5	7,6	8,0	8,4	4,6	6,9	4,7
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	8,2	9,3	7,0	7,7	8,3	8,2	7,6	7,2	6,6
Эрдэс бүтээгдэхүүн	19,5	18,1	16,6	19,6	22,8	19,2	20,5	23,2	27,6
Химийн болон химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн	5,6	5,8	3,9	4,6	5,3	5,0	5,4	4,6	4,6
Нэхмэл бүтээгдэхүүн	5,7	6,3	9,0	13,0	9,9	12,2	10,4	10,0	6,4
Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн	7,0	5,6	3,8	3,7	4,7	4,5	5,5	6,9	7,2
Машин, механик тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, эд анги, дуу хураагч эдгээрийн сэлбэг	26,7	25,2	34,5	21,7	17,8	19,5	21,0	19,7	21,6
Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, эд анги	9,6	13,5	10,6	10,9	10,8	10,9	10,8	10,2	9,8
Бүгд	89,1	89,1	88,9	88,7	87,7	88,0	85,8	88,7	88,6

Нийгэм-соёлын хүчин зүйл: Нийгэм соёлын хүчин зүйлд багтдаг тогтсон хэв зуршил, амьдралын үнэ цэнэ болон уламжлал гэх мэт зүйл байгууллагад нөлөөлдөг. Зарим оронд хожоотой гэрээ хэлэлцээр байгуулах буюу улс төрийн хожоо гаргах зорилгоор хахууль өгөх, мэдэц мэдлэгээрээ биш тал засан ивээлд багтах, өрсөлдөгчдөө гутаах явуулга хийх, цуу тараах зэргийг ёс зүйд нийцэхгүй гэж үздэг байхад зарим оронд хуулийн эсрэг гэж үзэхгүй бөөрөнхийлөх, заримд нь хэвийн гэж хэвшсэн байдаг. Энэ бүхэн байгууллагад янз янзаар нөлөөлдөг. Мөн эмэгтэйчүүдийг удирдах ажилд тэнцдэггүй гэсэн үзэл бодол, хэв зуршил ч байдаг.

Ажилчдын зорилго, чиглэл ч өөрчлөгдөж байна. Түрүү үедээ ажилчдын татагддаг байсан зүйл өөрчлөгдөж өнөөгийн залуу үе хараат биш байх, ажил дээрээ нийгмийн хамтын ажиллагаа явуулах, талархах дургүйцлээ ч илэрхийлж уян хатан хандах, утга төгөлдөр байж өөрийгөө хүндэтгэх, гэхдээ чөлөөт байдалд хор хохирол учруулахгүй байх, ажилласан тухайн газартаа тогтвортой байх гэх мэт шинэлэг хандлага тэмүүлэл бий болжээ. Энэ бүхнийг ялангуяа менежер хүн нягт харгалзах шаардлага ихэссэн байна. хүмүүсийн /хэрэглэгчдийн/ хэрэглээний уламжлал, үндэсний онцлог байгууллагад нөлөөлдөг.

Зах зээл хөгжихийн хэрээр хүн ардын мэдлэг боловсрол дээшилж, сүүлийн жилүүдэд манай хүн амын дийлэнх хувийг эзэлж байгаа залуучуудын боловсрол, нийгэмших соёл нь өсч хэрэглээнд нь хүртэл өөрчлөлт орсон. Тэд архины хэрэглээнээс аль болох татгалзах хандлагатай болсон. Мөн өөрсдийн

хэрэглэж байгаа бараа бүтээгдэхүүнийг сонгох тал дээр илүү их анхаарах болсон байна. энэ нь байгаль орчинд аюулгүй, байгалийн гаралтай, эрүүл бүтээгдэхүүнийг хэрэглэх эрмэлзэл, соёлтой хэрэглээг сонгоход нь нааштайгаар нөлөөлж байна.

Улс төрийн хүчин зүйл: Улс төрийн зарим зорилго байгууллагын удирдлагад онцгой ач холбогдолтой байдаг. Тухайлбал, бизнесийн талаархи засаг захиргаа, хууль тогтоох байгууллага, шүүхийн байгууллагын санаа бодол, хандлага чухал үүрэгтэй. Улс төрийн тогтвортой, тогтворгүй байдал, зах зээл, үйлдвэрлэлд заавал нөлөөлдөг.

Харилцагч улсуудын бодлого, манайтай харилцах албан харилцаа зэрэг нь үйлдвэрлэлд нөлөөллөө үзүүлнэ. Тухайлбал ОХУ үхрийн махны квотоо өнгөрсөн оноос эхлэн 80,000тн-р нэмэгдүүлсэн. Энэ нь бидэнд мах экспортлох боломжийг олгож байна. Мөн Хятадын Засгийн газраас үхэр хонины махны үйлдвэрлэлийг дэмжиж, харин гахайн махны үйлдвэрлэлийн хэмжээг бууруулахыг зорьж байна. Энэ нь манай хувьд өсөн нэмэгдэж буй хэрэгцээ бүхий оронд өөрийн үхэр, хонины махыг экспортлох боломжтой болохыг харуулж байна. Хятад улс ДХБ-д элссэн нь манай улсаас тус зах зээлд гарах өргөн боломжийг нээлээ.

Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн дотор тогтвортой хөгжил, экологийн тэнцвэрт байдлыг хангах, байгаль орчны бодлогыг бус нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан хэрэгжүүлэх асуудлууд тусгагдсан бөгөөд эдгээр нь Засгийн газраас боловсруулсан хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөрийн тэргүүлэх зорилтын нэг болж байна.

Экологийн орчин: Байгалийн хүчин зүйл, үүнтэй холбогдох төрийн бодлого, хууль тогтоомж нь бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлдөг. Жишээлбэл жил дараалан гарч байгаа малын гоц халдварт А зэрэглэлийн өвчин Монгол Улсын хувьд сөрөг нөлөө үзүүлдэг. Мөн ган зудын аюул байгалиас хэт хараат байгаа манай орны хувьд мал сүргийн тоо толгойд сөргөөр нөлөөлж болох талтай.

Манай улсад агаарын бохирдол ихсэж байна. Хог хаягдал нь метан, фуран, диоксин, нүүрсхүчлийн хий зэрэг эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй химийн хорт нэгдлүүдийг ялгаруулдаг. Төрөөс баримтлах бодлого нь байгальд аюул учруулах үйлдвэрлэлээс аль болох зайлсхийж, харин сөрөг нөлөөлөлгүй үйлдвэрлэлийг дэмжиж байдаг. Хор учруулах ч зайлшгүй байх ёстой үйлдвэрүүдэд энэ талаарх зардал нь өсч байдаг.

Аюултай хог хаягдлаар байгаль орчныг бохирдуулсны улмаас их буюу онц их хэмжээний хохирол учруулах, химийн гаралтай хорт бодис болон үйлдвэрлэлийн хортой хог хаягдал, цацраг идэвхт химийн бодис бордоог хадгалах, ашиглах, тээвэрлэх, булшлах талаар тогтоосон журмыг зөрчсөний болон байгаль орчны тэнцвэрт байдлыг ноцтой алдагдуулсны улмаас хүний эрүүл мэнд буюу байгаль орчинд их хэмжээний хохирол учирсан буюу учирч болох эсвэл газрыг бохирдуулсан хөрсийг гэмтээвэл хариуцлага хүлээлгэхээр

“Монгол улсын эрүүгийн” шинэ хуульд заасан нь байгаль орчинд болзошгүй аюул ослын эрсдэлийг багасгах, экологийн тэнцлийг хадгалахад чиглэгдсэн чухал арга хэмжээ болжээ.

Хүн амзүйн хүчин зүйл: Тухайн улсын хүн амын байршил, гэр бүлийн амьдралын мөчлөг, дундаж наслалт, дундаж орлого, нягтшил зэрэг хүн амтай холбоотой, бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж болох бүхий л хүчин зүйлсийг энд хамруулна. Хүн амын байршил, төвлөрөл, нас, хүйс, эрхэлсэн ажил, үндэсний онцлог, зан заншлын ялгаатай байдал нь бүтээгдэхүүн үйлдвэрлэлд, борлуулалтын үйл ажиллагаанд нөлөө үзүүлдэг.

Монгол орон засаг захиргаа нутаг дэвсгэрийн хувьд аймаг, нийслэлд, аймаг нь сумд, сум нь багт хуваагддаг. Харин нийслэл нь дүүрэгт хуваагддаг. Өнөөдрийн байдлаар монголд 21 аймаг, 340 сум, 1670 баг байна.

Хүн амын өсөлтийн прогноз

Зорилтот насны бүлгүүд	Нийт хүн амд эзлэх хувь					
	Бодиг			Хэтийн тооцооны		
	1990	2000	2005	2010	2015	2020
Хүүхэд /0-14 нас/	41,5	35,8	32,6	27,5	26,2	24,7
Хөдөлмөрийн нас /15-64/	54,4	60,8	63,8	68,5	69,7	70,6
Ахмад насны хүн ам /64+/	4,1	3,4	3,5	4,0	4,1	4,7
Нийт хүн ам	2153,4	2389,7	2562,4	2741,8	2918,6	3087,0

Монгол улсын хүн амыг насны бүтцийн хувьд авч үзвэл 32,6 хувь нь 16 хүртлэх насныхан, 63,9 хувь нь 15-64 насныхан, үлдсэн 3,5 хувь нь 65 ба түүнээс дээш насныхан эзэлж байна. Эндээс дүгнэвэл, Монгол улс залуу хүн амтай улсын тоонд зүй ёсоор орно.

Манай улсын нийт хүн ам 2006 оны дүнгээр 2594.1 мянга болж урд оныхоос 1,4 өссөн байна.





Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд хvн амын өсөлт 1.4 хувь, хөдөлмөрийн насны хvн амын өсөлт дунджаар 3.4 хувьтай байна. Ялангуяа vнд 16-29 насны залуучуудын эзлэх хувь харьцангуй өндөр байна. Нийт хvн амын дотор хөдөлмөрийн насны хvн ам 1488.9 мянга, эдийн засгийн идэвхитэй хүн ам буюу ажиллах хүч 959.8 мянга, ажиллагчдын тоо 926.5 мянга болсон байна. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгvй иргэдийн тоо 2005 оны байдлаар 35.6 мянга болж, ажилгvйдлийн тvвшин 3.4 хувьтай байна.

Нийт хүн ам ба ядуу хүн амын өсөлт

Байршил	Нийт хүн амын өсөлт /мян.хүн/		Ядуу хүн ам /мян.хүн/			Ядуу хүн амын өсөлт /мян.хүн/	
	1995-98	1998-02	1995	1998	2002	1995-98	1998-02
Улсын дундаж	107	88,4	828	849,8	894,0	21,8	44,2
Хот	30,1	119,8	471	493,4	415,3	22,4	-78,1
Үүнээс УБ	39,9	97,5	214	221,6	203,8	7,6	-17,8
Аймгийн төв	-9,8	22,3	257	271,8	211,5	14,8	-60,3
Хөдөө	76,9	-31,4	357	369,9	478,7	12,9	108,8

Ядуурлын тvвшин 2004 оны байдлаар 36.1 хувь буюу нийт хvн амын 36.1 хувь нь ядуу амьдарч байна.

Хот хөдөөгийн ядуурлын түвшний харьцуулалт



Хот, хөдөөд ядуурлын түвшин дээрх байдалтай байна. Нийгмийн баялгийн хуваарилалтын хувьд авч үзвэл хүн амын 10,10% нь нэн ядуу амьдарч байна.

Улаанбаатар хотын нэг өрхийн сарын дундаж орлого нь 120,000 төгрөг байгаа ба энэ орлогынхоо 4,1%-г ахуйн хэрэглээнд зарцуулдаг гэсэн статистик мэдээ 2005-06 сарын байдлаар гарсан байна.


Аймаг бүр өөр өөрийн дадал заншилтай соёлын өв сантай бөгөөд нийт 21 аймагт хуваагддаг. Ястан, үндэстний байдлаар олон хэсгүүдэд хуваагдах бөгөөд тус бүртээ өвөрмөц ялгаа бүхий хэрэглээний соёлтой болно. Энэ бүхэн нь монголын өнцөг булан бүрт бизнесийн харлихан адилгүй нөхцөл зах зээлийн боломж байх бодит үндэс болж байна. Худалдан авах шийдвэрт нөлөөлдөг соёлын онцлог зүйлсийг илрүүлэхэд урлаг, баяр наадам, бэлэг сэлт, хоол ундны бүтэц, тоо, өнгөний бэлгэдэл зэргийг нарийвчлан судлах нь их ач холбогдолтой.

2006 оны байдлаар Улаанбаатар хотод 210900 өрх гэр байна гэсэн тоо байна. Нэг өрхөд дундажаар 4,6 хүн амьдардаг. Манай улсын хүн амын /нэг өрхийн/ сарын дундаж орлогын бүтцийг авч үзвэл дараах байдалтай байна.

Нэг өрхийн сарын дундаж нийт болон мөнгөн орлогын бүтэц, 2005 он

	Хот	Хөдөө
Нийт орлого-Бүгд	100,0	100,0
Мөнгөн орлого-Бүгд	94,8	80,8
Цалин	55,6	14,4
Тэтгэвэр, тэтгэмж	11,3	8,9
Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний орлого	19,0	52,3
Бусад	8,8	5,3
Бусдаас үнэгүй авсан	3,7	2,5
Өөрийн хувийн аж ахуйгаас бэлтгэсэн хүнсний зүйлс	1,5	16,7

Улаанбаатар хотын хүн ам /Монгол улсын/ жил ирэх тутам байнгын цэвэр өсөлттэй байгаа, хөдөөгөөс хот руу чиглэсэн шилжилт эрс нэмэгдэж байгаа зэрэг нь нэг талаас худалдан авагчдын тоо өсөх таатай боломжийг бий болгож байгаа гэсэн өнгөц дүгнэлтэнд хүргэж байна.



Улаанбаатар хотын хүн ам ба өрхийн байршил нь дараах байдалтай байна. /сууцны хувьд/

Монгол улсын хэмжээнд үйлдвэрлэлийн дундаж хөдөлмөрийн бүтээмж 2005 оны байдлаар 2362,4 мянган төгрөг, харин ажиллагсадын жилийн дундаж цалин 101,2 мянган мөгрөг байна.

Хөдөлмөрийн бүтээмж, дундаж цалингийн харьцаа /улсын түвшинд, оны үнээр/

	2002	2003	2004	2005
Хөдөлмөрийн бүтээмж /мян.төг/	1457,1	1626,0	2036,1	2362,4
ААН, байгууллагад ажиллагсадын жилийн дундаж цалин /мян.төг/	71,3	81,5	93,1	101,2

Орон нутгийн хүн амтай харьцах харьцаа: Аж үйлдвэрийн газрыг зарим нутагт хөгжүүлэх, гэтэл заримд нь хөгжүүлэхгүй, хөдөөг хот болгохгүй сонирхолтой байдаг. Энэ тухайд орон нутгийн удирдлага, хүн амын хооронд зөрчил ч үүсгэдэг. Тухайн орон нутгийн хүн амын зорилго, санал бодлыг гарцаагүй харгалзах шаардлагатай.

Олон улсын хүрээлэл: Бизнесийн байгууллагын удирдлага үйл ажиллагааг дотоодод болон гадаадад явуулахад өөр өөр гэдгийг харгалзах ёстой. Тэгээгүйгээс сүйрэх явдал ч байдаг.

Олон улсын бизнесийн удирдлагын хөгжил: Нөөц, таваар, үйлчилгээ болон ажиллах хүчнийг нэг орноос нөгөөд шилжүүлж ашиглахтай холбогдуулж олон улсын бизнес явагддаг учир түүнийг зохистой удирдах асуудал тавигддаг. Үйлдвэрлэлийн нөөцүүд, технологи, бэлэн бүтээгдэхүүнээс гадна нягтлан бодох, хууль, банкны ажиллагаа, мөн мэргэжилтэн, техникийн хүмүүс болон менежерийг гадаадад шилжүүлэн ашиглаж болно. Гадаад орнуудад бизнес эрхлэх нь:

- Үйлдвэрлэлийн зардал мэдэгдэхүйц бага
- Худалдааны хаалт саадыг давах боломж их
- Гадаад орноос ашиг олох боломж их зэрэг давуу талтай байдаг.

Олон улсын бизнесийн төрлүүд: Экспорт бол олон улсын зах зээлд гарах хамгийн хялбар дөт зам юм. Байгууллага экспортоо тууштай нэмэгдүүлж түүнийгээ найдвартэй гэж үзвэл дунд түвшинд экспортын хэлтэс ч байгуулж болох юм.

Лецинзийн худалдаа: байгууллага нь өөрийн бүтээгдэхүүний лецинзийг гадаадын пүүс болон улсад худалдаж болно. Энэ маягаар АНУ-н пүүсүүд гадаадын компани болон улсад патент буюу технологи, үйлдвэрлэлийн нууцаа ашиглах эрх олгодог. Түүнчлэн технологийн болон захиргааны талаар тус

дэмжлэг үзүүлдэг. Гадаадын компани буюу улсууд нь лецинзийн төлбөр, үйлчилгээний төлбөр төлдөг.

Хамтарсан үйлдвэр: нь 2 буюу түүнээс дээш тооны хувийн компаниуд болон улс, тухайн орны нутагт үйлдвэрлэлийн тодорхой хүчин чадлыг бий болгоход зориулж хамтран хөрөнгө оруулах замаар үүсдэг. Ажил төрлөө эрхлэх, ашгаа хуваахад хамтарсан үйлдвэр оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр эзэмшиж буй хувьцааныхаа хувиар тэгш эрх эдэлнэ.

Шууд хөрөнгө оруулалт: Удирдлага нь өөрийн пүүсийн бүтээгдэхүүнийг гадаад оронд үйлдвэрлэж үйлдвэрлэл, маркетинг, санхүү болон бусад гол үүргүүдийн хяналтыг бүрэн хадгалж буй тохиолдолд шууд хөрөнгө оруулдаг.

Олон үндэстний корпораци: нь бусад орнууд дах үйлдвэрийн газруудыг эзэмшиж удирддаг. Одоо дэлхийн хамгийн том 100 гаруй корпораци 20 гаруй оронд өөрийн салбартай болжээ.

Олон улсын орчны хүчин зүйлүүд: Олон улсын аль нэг орчны шинж байдал өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дасгахын тулд байгууллагын удирдлага нь олон улсын орчин бүрийн хүчин зүйлүүдийг мэддэг байх ёстой. Энд доорхи гол хүчин зүйлүүд үйлчилдэг. Соёл, эдийн засаг, хууль тогтоомж, төрийн зохицуулалт болон улс төрийн нөхцөл байдал.

Соёл: гэдэг бол нийгэмд ноёрхож буй бүгдийн хуваалцдаг үнэ цэнэ, шүтлэг, хэв суртал, заншил болон зонхилж буй зорилго чиглэлийн систем юм. Энэ нь улс бүрт янз бүр. Цаг хугацааг АНУ-д алтнаас эрхэм үздэг бол Дорно дахины соёлд цагийг эхлэл төгсгөлгүй гэж үзэх жишээтэй. Соёлын нэг тал нь хэл юм. Хилийн чанадад үйл ажиллагаагаа явуулахад хамгийн их бэрхшээл учруулдаг зүйл нь хэл. Ер нь өөр соёлын нөхцөлд ажиллахтай холбогдсон хүний асуудал л амжилт олохгүйн гол шалтгаан болдогийг шинжээчид тогтоожээ.

Эдийн засаг: эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал байгууллага, түүний өөрчлөлтөд яаж нөлөөлөхийг удирдлага анхаарах ёстойг дээр дурдсан. Гадаад оронд үйл ажиллагаагаа эрхэлж буй буюу эрхлэхээр зэхэж буй байгууллага тэр орныхоо эдийн засгийг сайн судлах учиртай. Энд дараах хүчин зүйлүүдийг анхаарах шаардлагатай байдаг:

Цалингийн түвшин, унааны зардал, төлбөр, валютын ханш, инфляци, хүүний түвшин, үндэсний болон дотоодын нийт бүтээгдэхүүн, татварын систем, эдийн засгийн ерөнхий төлөв байдал зэрэг болно.

Цэвэр эдийн засгийн бус анхаарч судлах зүйл бас байдаг. Тухайлбал хүн амын тоо, бичиг үсгийн мэдлэг, мэргэжлийн түвшин, байгалийн баялгийн хэмжээ, чанар, технологийн байдал, өрсөлдөөн тэмцлийн онцлог гэх мэт.

Эцэст нь тэмдэглэхэд тухайн орны хууль, төрийн зохицуулалт, улс төрийн нөхцөл, бодлогын өөрчлөлтийг заавал анхааралтай судалж мэдсэн байх шаардлагатай.

Одоо бид зах зээлийн эдийн засгийн тогтолцоог ашиглан эрчимтэй хөгжих хөгжлийн гараан дээр ирээд байна. Энд хөгжлийг зөв замаар эрчтэй явуулах төрийн мэргэн бодлого чиглэл чухал юм. Өнгөрсөн 80 гаруй жилийн эдийн

засгийн бүтцийг үзвэл түүхий эдэд суурилсан анхдагч салбар буюу хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуйн салбар ДНБ-д голлох үүрэгтэй байсан нь харагдаж байна. Харин улс орны хөгжилд чухал үүрэгтэй аж үйлдвэр, үйлчилгээний салбарын хөгжил ямагт удаах байранд нь явж иржээ. Иймээс Монгол улс эрчимтэй хөгжихийн тулд эдийн засгийн бүтцээ үндсээр нь өөрчлөх шаардлагатай.

Хөгжлийн бодлого стратегийг тодорхойлох, томьёолохдоо улс орныхоо хөгжлийн давуу болон сул талыг нарийвчлан судалж үнэлгээ дүгнэлт хийх шаардлагатай.

Монгол Улсын хөгжлийн давуу талуудад:

1. Бараг бүхэлдээ онгон төрхөөрөө хадгалагдан үлдсэн байгалийн өвөрмөц цогцолбор, ховор амьтан, ургамлын төрөл зүйл бүхий өргөн уудам газар нутаг.
2. Хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглаж болох эдэлбэр газрын харьцангуй их нөөц
3. Байгал орчиндоо зохицсон дэлхийд ховор бэлчээрийн уламжлалт мал аж ахуй, түүнд зохицсон нүүдлийн амьдралын өвөрмөц хэв маяг, соёл иргэншил.
4. Эрдэсийн түүхий эдийн олон төрлийн баялаг нөөц.
5. Хүн амын боловсролын харьцангуй өндөр түвшин.
6. Хөрш орнууд, бүс нутгийн зах зээлийн багтаамжийг ашиглан үйлчилгээний эдийн засгийг хөгжүүлэх таатай нөхцөл.
7. Төв Азийн болон Европын орнуудыг Зүүн хойд болон Зүүн өмнөд Азийн орнуудтай холбох газар зүйн байршил.
8. Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эдэд түшиглэн экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж зэргийг дурьдаж болно.

Хөгжлийн сул талууд:

1. Хүн амын тоо цөөн, таруу байршилтай, хөдөлмөрийн нөөц хязгаарлагдмал, ялангуяа мэргэжлийн өндөр ур чадвартай ажилчид, зах зээлийн мэдлэгтэй мэргэжилтний тоо цөөн.
2. Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түвшин доогуур, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанараар дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвар сул.
3. Уур амьсгал нь эрс тэс, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл байгалиас ихээхэн хамааралтай.
4. Эдийн засгийн өрөөсгөл бүтэцтэй, дэд бүтэц сул хөгжсөн.
5. Тивийн болон бүс нутгийн, олон улсын гол зам харилцаанаас алслагдсан, далайд гарцгүй.
6. Экологийн эмзэг орчинтой, байгалийн нөхөн сэргэх чадвар сул.
7. Хөрөнгө, санхүү валютын нөөц ихээхэн хязгаарлагдмал, экспортын боломж нөөц бага зэргийг нэрлэж болно.

Манай улсын хувьд шилжилтийн үеийн эдийн засаг, нийгмийн хүнд хэцүү хямралын үеийг давж, эдийн засаг бүхэлдээ тогтворжин улмаар тодорхой өсөлт гарч байгаа өнөө үед улс орныхоо эрчимтэй хөгжлийн чиг хандлагыг

оновчтой тодорхойлсон “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-г боловсруулан хэрэгжүүлэх нь нийгмийн шаардлага, захиалга болж байна.

Монгол Улсын үндэсний хөгжлийн бодлого, стратеги, Монгол орны хувьд нүүдлийн соёл иргэншлийн шилдэг өв уламжлалыг хүн төрөлхтний орчин үеийн шилдэг ололттой зохистой хослуулж чадвал хөгжил дэвшил түргэсэх боломжтой.

Монгол орны хөгжлийн агуулга нь **үндэсний бүтээх чадамжийг** дээшлүүлэх замаар **хүн ардынхаа амьдралын чанарыг дээшлүүлж хүний хөгжлийн таатай орчинг бүрдүүлэх явдал мөн.** Энэхүү агуулга нь эдийн засгийн бодлого санаачлагаар илэрхийлэгдэн биелэлээ олох учиртай. Монгол улсын эдийн засгийн зорилго нь орчин үеийн технологид түшиглэсэн, зохистой бүтэц бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ, эрчимжсэн хөдөө аж ахуйн өөрийгөө тэтгэх чадамжтай, идэвхтэй эдийн засгийг төлөвшүүлэн хөгжүүлэхэд оршино.

Монголын хөгжлийн загвар:



Хөгжлийн шалгуур:

Монголы улсын 2021 он хүртэлх 15 жилийн хөгжлийн стратеги нь шинжлэх ухаан, технологийн сүүлийн үеийн ололт, өндөр технологид түшиглэсэн, зохистой бүтэц бүхий аж үйлдвэр, эрчимжсэн хөдөө аж ахуй, оюуны өндөр боловсрол, эрүүл чийрэг бие бялдар, элбэг хангалуун амьдрал бүхий хүн амтай, ядуурал, гуйланчлал, өлсгөлөнгүй, байгалийн унаган төрхөө хадгалсан, олон улсын банк санхүүгийн сүлжээнд нэгдсэн, өрсөлдөх чадвар бүхий өөрөө өөрийгөө тэтгэх бие даасан эдийн засагтай, ардчилал, хүний эрхийг дээдэлсэн орон болоход оршино.

Монгол орон 2015 он гэхэд үйлчилгээ үйлдвэр ДНБ-ний 85 орчим хувийг эзэлсэн, нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 6000 орчим ам.долларт хүрсэн, хүн амын дундаж наслалт 70, бүх нийтээрээ суурь боловсрол эзэмшсэн орон болно.

2021 он гэхэд ДНБ-д үйлчилгээ, аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 92,0 болж, үүний дотор боловсруулах аж үйлдвэр 20,5%-с доошгүй байх, нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ 10000 орчим ам.долларт хүрч, дундаж орлоготой орнуудын түвшинд хүрэх ба хүн амын дундаж наслалт 75, бүх нийтээр 12 жилийн боловсролтой орон болно.

Дээрх зорилгод хүрэхийн тулд эдийн засгийн богино, дунд, урт хугацааны бодлогуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Богино хугацаанд бол өндөр инфляцийг хязгаарлан, дунд хугацаанд хөдөө аж ахуй, уул уурхайн салбараас хамааралтай эдийн засгийг дэмжин,

тогтвортой хэрэглээнд суурилсан, дэлхийн болон бүс нутгийн банк санхүүгийн системд багтсан, экологийн цэвэр зарим бүтээгдэхүүнээр төрөлжсөн, аж үйлдвэрийн бүтцийн тасралтгүй шинэчлэлттэй мэдээлэл, харилцаа холбооны технологийг хослуулан хөгжүүлэх замаар үйлдвэрлэл, үйлчилгээний эдийн засагт шилжих бодлого, стратегийг баримтлах нь зүйтэй.

Түүнчлэн эдийн засгийн бага инфляц, тогтвортой үнэ бүхий бие даасан өсөлтийг хангах зорилгоор бүтээмжид тулгуурласан бодлого хэрэгжүүлэх нь чухал. Бүс нутгийн гео эдийн засгийн онцлогт түшиглэсэн үйлчилгэжсэн үйлдвэрлэлд чиглүүлж болох бөгөөд ингэхдээ эдийн засгийн өсөлтийг хангаж, өрсөлдөх чадварыг өндөр байлгахын тулд бүтээмжид тулгуурласан сэдэл санаачлагатай хослуулах шаардлагатай. Эдийн засагт хүмүүн капиталыг бүтээн босгох, мэдлэг шингээх, хэрэглэх чадамжийг дээшлүүлэх, сайн менежментийг хэрэглэх явдалд илүүтэй анхаарах нь зүйтэй. Үндэсний хөгжлийн үе шат:

Үндэсний хөгжлийг дараах үе шатаар авч үзвэл зохино.

Эхний үе шат: 2006-2010 оны хооронд эдийн засгийн өсөлтийн баттай суурийг тавина. Энэ үе шатанд эрдэс түүхий эдийн шинэ шинэ орд газруудыг эзэмших замаар уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэрийг хуримтлал бүрдүүлэх эх үүсвэр болгон хөгжүүлж, мал аж ахуйн гаралтай түүхий эдэд түшиглэсэн экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, боловсруулах аж үйлдвэрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ, аялал жуулчлал, авто зам, мэдээлэл холбооны технологи, эрчим хүч зэрэг үйлчилгээ, дэд бүтцийн салбарыг илүү хурдацтай хөгжүүлнэ.

Эхний үед манай орын дотоодын нийт бүтээгдэхүүн хэрэгцээг бүрэн хангахгүй учраас шаардлагатай хөрөнгө оруулалт болон гадаад худалдааны алдагдлыг нөхөхөд санхүүжилтийн гадаад эх үүсвэр зайлшгүй шаардлагатай байна.

Завсрын үе шат: 2011-2015 оны үед уул уурхайн олборлох салбараас боловсруулах салбар луу шилжиж, эрдэс түүхий эдээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ. Оюуны багтаамж ихтэй үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлнэ. Эдийн засгийн өсөлтөд чухал үүрэгтэй авто зам, эрчим хүч, мэдээллийн технологи, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарыг эрчимтэй хөгжүүлнэ.

Мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто замыг бүрэн, босоо тэнхлэгийн авто замын дийлэнхийг барьж ашиглалтанд оруулна. Мөн аймгийн хооронд болон аймгийн дотоодын авто замын сүлжээг бий болгон сайжруулах арга хэмжээ авна.

Бүх аймгийн төвүүдийг мэдээлэл харилцаа холбооны өндөр хурдны, өргөн зурвасын сүлжээнд, бүх сум суурин газрыг тоон сүлжээнд холбох, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх, мэдээлэл холбооны утасгүй дэвшилтэт технологи нэвтрүүлэх, бүх нийтийг компьютержуулах, интернэтэд холбох, цахим засаглалыг хөгжүүлэх, төрийн мэдээллийн өндөр хурдны сүлжээ, нэгдсэн сан байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Бүх багт шуудан хүргэнэ.

Мал аж ахуйн салбарт фермерийн аж ахуйг хөгжүүлэх, бүсийн тулгуур төвүүдийг бараадсан газар тариалан, мал аж ахуйг эрчимжүүлж, усалгаатай тариаланг түлхүү хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. Шинэ нэр төрлийн хүнсний ургамал, малын тэжээл тариалах зорилтыг хэрэгжүүлнэ. Үндэсний эдийн засагт цахим арилжаа, программ хангамж, аялал жуулчлалын салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлнэ.

Энэ шатанд үндэсний дотоодын нийт бүтээгдэхүүн өсч, энэ нь дотоод хуримтлал бий болж, нэмэгдэх нөхцөл боломжийг бүрдүүлэх бөгөөд ингэснээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа гадаадын хараат байдлаас ангижирч, гадаад худалдааны баланс сайжирна.

Алсын үе шат: 2016-2021 он гэхэд эрчим хүчний хангамж, мэдээлэл холбооны өндөр хурдны өргөн зурвасын нэгдсэн сүлжээний асуудлыг бүрэн шийдвэрлэж, газрын тосоор өөрийгөө хангаж, эрчим хүчний шинэ эх үүсвэр болох АЦС-ыг ашиглана. 2016-2021 оны хооронд төвийн бүсээс баруун бүс рүү төмөр зам барих ажлыг эхлүүлсэн байхын дээр зарим томоохон хот суурин газрыг цахилгаан соронзон замаар холбож, зорчигч тээвэрлэлтэд шинэ тээврийн хэрэгсэл, үүрэн телефоны шинэ технологи, сансрын холбоог өргөн ашиглах болно.

Энэ үе шатанд ДНБ илүү хурдацтайгаар өсч, улс орны дотоод хуримтлалын сонирхол төлөвшин нэмэгдэж, гадаадаас авсан өр зээлийг төлөхөд хүрэлцэхүйц хэмжээний гадаад худалдааны илүүдэлтэй болж өөрийгөө тэтгэх эдийн засаг төлөвшин бүрдэнэ.

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд гадаад орчны нөлөөлөл буюу дэлхийн хөгжлийн чиг хандлага ихээхэн нөлөөлөх нь тодорхой. Олон улсын түвшин дэх гадаад орчин бүр ч баримжаагүй, ээдрээтэй байдаг билээ.

Ашигласан ном, зүй

1. Т.Дорж, Ү.Чимэд. “Менежмент” УБ.2008 он
2. Н.Цэнд нар. “Менежмент” УБ. 2009 он
3. Монгол Улсын Статистикийн эмхтгэл УБ.2008 он